

БАТЛАВ  
ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗРЫН  
ДАРГА Э.БАТТУЛГА

2026 оны 01 дүгээр сарын ....

ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН  
АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД  
2026 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах нэгж, комисс
<b>Зорилт 1:</b> Албан хаагчдын ажлын байрны орчин, нөхцөлийг сайжруулах зорилтын хүрээнд:			
1	Шаардлагатай ажлын байрны дотоод орчныг тохижуулах, эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэх	Жилдээ	ЗХ
2	Жил бүрийн төсөвт ажиллах орчныг сайжруулах, засвар үйлчилгээний урсгал зардлыг тусгах	Тухай бүрд	ЗХ
3	Албан хаагчдыг албан үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай компьютер, тоног төхөөрөмж, бичгийн хэрэгслээр хангах	Жилдээ	ЗХ
4	Ажлын байрны цэвэрлэгээ үйлчилгээнд хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, харшил үүсгэдэггүй, угаагч, ариутгагч бодис ашиглах шаардлага тавих	Жилдээ	ЗХ
5	Шинээр ажилд орж байгаа албан хаагчийг байгууллагын соёл, ажилдаа дасан зохицох арга хэмжээг авч хэрэгжүүлэх	Тухай бүрд	ЗХ
<b>Зорилт 2:</b> Цалин хөлс, нэмэгдэл, шагнал урамшуулал, тэтгэвэр тэтгэмж, нөхөн төлбөр, тусламж дэмжлэгийг хуулийн хүрээнд үзүүлэх зорилтын хүрээнд:			
1	Засгийн газраас баталсан албан тушаалын цалингийн сүлжээг баримтлан албан хаагчдын цалинг тухай бүр шинэчлэн тогтоож мөрдөх	Тухай бүрд	ЗХ
2	Албан тушаалын цалин, нэмэгдэл, суутгал, шимтгэл зэргийг тусгасан мэдээллийг сар бүр тухайн албан хаагчид гаргаж өгөх	Тухай бүрд	ЗХ
3	Ажлын шаардлагаар илүү цагаар болон баяр ёслолоор ажилласан албан хаагчийг нөхөн амрах эсвэл нэмэгдлийг олгох	Тухай бүрд	ЗХ
4	Шөнийн цагаар ажилласан албан хаагчдын нэмэгдэл, хөлсийг хөдөлмөрийн хуульд заасны дагуу олгох;	Тухай бүрд	ЗХ
5	Албан хаагч ажлын онцлогоос хамаарч ээлжийн амралтаа эдэлж чадаагүй тохиолдолд	12 дугаар сард	ЗХ

	хөдөлмөрийн хуульд заасны дагуу ээлжийн амралтын цалинг нэг аравны тав дахин нэмэгдүүлж олгох;		
<b>Зорилт 3:</b> Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалж, эрүүл амьдрах дадлыг хэвшүүлэх зорилтын хүрээнд:			
1	Албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт жилд 1 удаа хамруулах;	Жилдээ	3Х
<b>Зорилт 4:</b> Албан хаагчдын амьдрах нөхцөлийг сайжруулах боломжийг судлах зорилтын хүрээнд:			
1	Албан хаагчдын орон сууц, зуслангийн газрын судалгааг гаргах	Жилдээ	3Х
2	Төрийн албан хаагчдын амьдрах нөхцөлийг сайжруулах зорилгоор банкнаас ногоон зээл, бусад зээл авахад нь дэмжлэг үзүүлэх	Тухай бүрд	3Х
<b>Зорилт 5:</b> Төрийн албан хаагчийн нийгмийн хэрэгцээ, сэтгэл зүйн хандлагыг мэдэрч, байгууллагын соёл, хамт олны соёл, уур амьсгалыг өөрчлөх замаар албан хаагчдын ажлын байран дахь сэтгэл ханамжийг дээшлүүлэх зорилтын хүрээнд:			
1	Байгууллага хамт олны дунд найрсаг, бие биеэ хүндэтгэсэн соёлыг төлөвшүүлэх, албан хаагчдын зөв харилцаа, хандлага, сайн туршлагыг дэмжих, түгээн дэлгэрүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх	Жилдээ	Ёс зүйн дэд хороо
2	Ажлын байрны сэтгэл ханамжийн судалгааг жил бүр авч, тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх	Жилдээ	3Х